



МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/36

Улаанбаатар хот

Батлан хамгаалахын стратеги төлөвлөгөөг
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Батлан хамгаалахын стратеги төлөвлөгөө (2025-2028 он)”-г хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг яамны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Д.Ганхуяг, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал С.Ганбямба, төрлийн цэргийн командлагч, удирдах газар, нэгтгэл, анги, байгууллагын захирагч (дарга) нарт тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (хурандаа Б.Эрхэмбаяр)-т хариуцуулсугай.

САЙД



С.БЯМБАЦОГТ

7325100040

Батлан хамгаалахын сайдын 2025 оны
01 дугаар сарын 04 ны өдрийн
4/36 дугаар тушаалын хавсралт



БАТЛАН ХАМГААЛАХЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ (2025-2028 он)

УЛААНБААТАР
2025 он

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Эрх зүйн үндэслэл:

Батлан хамгаалахын стратеги төлөвлөгөөг Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1¹, Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1² дэх хэсэг, "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 7.1³ дэх зорилт, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг тус тус үндэслэн Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам"-ын дагуу боловсруулсан болно.

1.2. Төлөвлөгөөг боловсруулахад баримтлах зарчим:

Төлөвлөгөөг "Ухаалаг" (SMART) буюу зорилго тодорхой байх (S-Specific), хэмжиж болохуйц (M-Measurable), зорилгодоо хүрч болохуйц байх (A-Attainable), бодитой байх (R-Relevant), цаг хугацаатай байх (T-Time based) зарчмуудыг баримталлаа.

1.3. Төлөвлөгөөний хамрах хүрээ:

Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээний яам, агентлаг болон байгууллагуудын үйл ажиллагааг нэгдмэл байдлаар төлөвлөн, 2025-2028 онуудад хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

1.4. Төлөвлөгөөг боловсруулах хэрэгцээ, шаардлага:

Сүүлийн үед дэлхийн цэрэг-улс төрийн нөхцөл байдал нэн тогтворгүй хэвээр байна. Үндсэндээ улс орнуудын хөгжил дэвшилд нөлөөлж буй гадаад нөхцөл байдалд дэлхий, бүс нутгийн аюулгүй байдлын орчин, геополитик, хөрш орнуудын цэрэг-улс төр, нийгэм, эдийн засагт гарч буй өөрчлөлт, чиг хандлага, харин дотоод нөхцөл байдалд эдийн засаг, нийгмийн хөгжлийн болон иргэдийн боловсролын түвшин, эх оронч үзэл, төлөвшил, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт болон үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхын байдал зэрэг хүчин зүйлүүд голлох нөлөө үзүүлэх боллоо.

Өнөөг хүртэл олон хүчин зүйлээс үүдэн бүс нутгийн шинжтэй хямралт байдал бий болсоор байгаа нь улс орнуудын аюулгүй байдлын талаарх уламжлалт ойлголтод хүчтэй нөлөөлж, олон улсын харилцаан дахь шинэчлэлийн үйл явц эрчимтэй өрнөхийн зэрэгцээ аюул, заналын талаарх ойлголт ч хувьсан өөрчлөгдөж, урьд өмнө байгаагүй шинэ төрлийн аюул, сорилтыг сөрөн зогсох үр дүнтэй шинэлэг арга хэлбэрийг шаардах болсон.

Ялангуяа сэргэлдэгч талууд орчин үеийн техник, технологид суурилсан шинэ арга, хэрэгслийг ашиглах болж, кибер орон зайд ашиг сонирхлоо хамгаалах, давуу байдал олох сонирхол ихсэж, цаг хугацаанаас хамаарахгүйгээр мэдээллийн дэд бүтцийг бүрэн хянах, удирдах, мэдээллийг тэмцлийнхээ гол объект болгон ашиглах зорилгыг агуулах болсон байна.

Сүүлийн жилүүдэд геополитик, геостратегийн сэргэлдөөн хурцдаж, том гүрнүүдийн дунд "Хүчний төв"-ийн байр сууриа хадгалах, түүнийг олж авах өрсөлдөөн гүнзгийрч, үндэсний ашиг сонирхлыг тэргүүн эгнээнд тавьж, дэлхийн их

¹ 12.1. Яам нь чиг үүрэг, эрхэм зорилго, стратегийн зорилтоо хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөтэй ажиллана;

² 53.1. Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна;

³ 7.1. Улсын орны батлан хамгаалах тогтолцоог боловсронгуй болгож, чадавхыг бэхжүүлнэ.

гүрнүүд нэг нь нөгөөгийнхөө эсрэг улс төрийн болон эдийн засгийн хориг арга хэмжээ авч, өөрийн нөлөө, хүрээгээ тэлэхийг эрмэлзэх боллоо.

Монгол Улсын оршин буй Ази, Номхон далайн бүс нутаг нь цэрэг, зэвсгийн хүч ихээр төвлөрсөн, улс төр, үзэл суртлын эрс ялгаатай улс, гүрнүүдтэй, цөмийн зэвсгийн аюулаас гадна уламжлалт бус аюул оршсоор байгаа нь манай улсын аюулгүй байдлын гадаад орчин тогтвортой биш байгааг илэрхийлж байна. Тэр дундаа Зүүн Хойд Азийн бүс нутагт цэрэг-улс төрийн нөхцөл байдалтай холбоотой ээдрээтэй асуудлууд байсаар байна.

Тухайлбал, Зүүн Хойд Азид тэргүүлэх байр суурийг бий болгохыг хичээж буй хоёр бүлэг орнуудын болоод АНУ, БНХАУ-ын хооронд өрнөж байгаа “шинэ хүйтэн дайн”, “эдийн засаг, технологийн дайн”-аас үүдэлтэй сөргөлдөөн үргэлжилсээр байна. Мөн хоёр Солонгосын байдал хурцадмал хэвээр байгаа ба Хятад, Тайванийн хоолой нь цэрэг, зэвсгийн төвлөрөлтэй бүс нутгийн хоёр дахь халуун цэгт тооцогдоод байгаа бол Хятад, Японы геополитикийн өрсөлдөөн улам нэмэгдэх хандлагатай байгаа зэрэг юм.

Монгол Улсын хувьд бүс нутгийн орнуудтай сайн харилцаатай, цөмийн зэвсгээс ангид статустай, аюулгүй байдлын тогтсон бодлоготой, улс орнуудтай тэнцвэртэй харилцаатай байдлаараа өөрийн байр суурийг бүрдүүлж, геополитикийн орчин, хөрш улс, газар нутаг, хүн ам, улс төр, эдийн засаг, нийгмийн онцлогтой уялдуулан аюулгүй байдлаа хангаж ирсэн. Цаашид энэ байр сууриа бэхжүүлэхийг зорьж, улс орнуудтай харилцах харилцааг тэнцвэртэй байлгахыг эрмэлзэж байна.

Манай улс хөрш хоёр оронтойгоо адил тэгш найрсаг харилцаатай ч тэдний гадагшаа нөлөөгөө тэлэх бодлого, дотоодын улс төр, үзэл суртлын хямралаас үүдэн үүсэж болзошгүй нийгмийн тогтворгүй байдал, салан тусгаарлах үзэл, терроризм зэрэг аюул, занал нь манай улсын аюулгүй байдлын орчинд сөргөөр нөлөөлөх магадлалтай байдаг.

Улс орны аюулгүй байдлын гол зангилаа асуудал нь батлан хамгаалах бодлого, түүнийг хэрэгжүүлэх тогтолцоогоор дамжин шийдвэрлэгдэж ирсэн. Иймд Монгол Улс улс орнуудын улс төр, нийгэм, эдийн засгийн тухайн цаг үеийн нөхцөл байдлаас үл хамааран төрийн бодлогын тэргүүлэх чанараа бүрэн хадгалж, удаан хугацаагаар үйлчлэх шинж чанарыг өөртөө агуулсан төрийн батлан хамгаалах бодлогын тулгуур баримт бичиг болох “Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичигтээ “Монгол Улс бүх нийтийн оролцоонд тулгуурласан батлан хамгаалах стратеги” буюу орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бүрдүүлэн бэхжүүлэх бөгөөд түүний үндэс нь “Төр, захиргааны байгууллагууд, нийт иргэний оролцоонд тулгуурласан орон нутгийн хамгаалалт, мэргэжлийн цэрэгт суурилсан зэвсэгт хүчин, нэгдмэл удирдлага, төлөвлөлт бүхий дайчилгаа” болохыг тодорхойлсон.

Улмаар Батлан хамгаалахын эрх зүйн хоёр дахь томоохон шинэчлэлтийг 2015 оноос эхлүүлж, Батлан хамгаалахын багц хууль, “Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги-2030”, Зэвсэгт хүчний байгуулалтыг 2024 он хүртэл хөгжүүлэх төлөвлөгөө, “Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлого” зэрэг бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийг Улсын Их Хурал, Засгийн газраар батлуулан хэрэгжүүлж байна.

Мөн Батлан хамгаалахын сайдын 2021 оны А/62 дугаар тушаалаар батлагдсан “Батлан хамгаалахын стратеги төлөвлөгөө (2021-2024)”-нд тусгагдсан 4 зорилт, 93 арга хэмжээний хэрэгжилтэд 2024 оны 12 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд биелэлт 79.6 хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдсэн.

Тус төлөвлөгөөнд тусгагдсан 93 арга хэмжээнээс зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, үр дүн гарсан буюу 100 хувьтай-46, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарсан буюу 70-90 хувьтай-26, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай буюу 50 хувьтай-10, зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай буюу 30 хувьтай-9, хэрэгжээгүй буюу 0 хувьтай-2 арга хэмжээ байлаа.

Батлан хамгаалах салбарын үйл ажиллагааны төсөв хязгаарлагдмал, улсын төсвийн хөрөнгө оруулалт шийдвэрлэгдээгүй нь төлөвлөгөөний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлсөн бөгөөд цаашид **“ТӨРИЙН БОДЛОГЫН ЗАЛГАМЖ ЧАНАРЫГ ХАДГАЛСАН БАЙХ”** зарчимд үндэслэн “Батлан хамгаалахын стратеги төлөвлөгөө (2021-2024)”-нд тусгагдсан боловч бүрэн хэрэгжээгүй арга хэмжээг ач холбогдлоор нь эрэмблэн Батлан хамгаалахын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөнд тусгах шаардлагатай гэж үзсэн болно.

Дээрх бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд батлан хамгаалах чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрсэн. Үүнд:

Батлан хамгаалахын хууль, эрх зүйн орчныг сайжруулах ажлыг шат дараалан хэрэгжүүлэн, Монгол Улсын батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх чиглэлээр 110 гаруй асуудлыг системтэйгээр боловсруулан, эрх бүхий субъектүүдэд уламжлан холбогдох шийдвэрүүдийг гаргуулсан. Тухайлбал:

- 2020, 2021 онд Зэвсэгт хүчний тухай хуульд 2 удаа, 2022 онд Тагнуулын байгууллагын тухай хууль, 2023 онд Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 2024 онд Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон тэдгээрийг дагалдан гарсан 5 хуулийг батлуулсан;

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 2021 онд “Цэргийн алба хаагчид цэргийн цол олгох журам”, 2022 онд “Монгол Улсын Цэргийн нийтлэг дүрмүүд”-ийг шинэчлэн батлуулж, Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудад мөрдөгдөж байна;

- “Улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөө” болон “Төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн дайчилгааны даалгавар”-ыг Монгол Улсын нийгэм, эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, мэдээлэлд тулгуурлан боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар батлуулсан;

- “Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлого” баримт бичгийг 2024 онд Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн батлуулсан;

- Улс орныг хөгжүүлэх стратегийн бүтээн байгуулалтын ажилд цэргийн алба хаагчдыг оролцуулснаар зарим томоохон төслүүд болох “Тавантолгой-Зүүнбаян”

чиглэлийн 416,1 км, “Зүүнбаян-Ханги” чиглэлийн 226 км төмөр зам, “Улаанбаатар-Дархан” чиглэлийн авто замын 30 байрлалд ус зайлуулах хоолой, 25 км-т далан барих, Өмнөговь аймгийн Гашуун сухайт боомт дахь “Автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал байгуулах” зэрэг ажлуудыг богино хугацаанд чанарын өндөр түвшинд хэрэгжүүлсэн;

- БХЯ-ны харьяанд анх удаа Зэвсэгт хүчинд ашиглагдаж байгаа болон бусад төрлийн сум үйлдвэрлэх “Зэв” УТУГ-ыг байгуулсан;

- Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалтыг өргөжүүлэх хүрээнд 2 ангийг өргөтгөн зохион байгуулж, Тусгай хүчний болон Кибер аюулгүй байдлын цэргийн командлалд тус бүр 1 анги шинээр байгуулсан;

- Батлан хамгаалах яамны бүтцэд “Улсын нисэхийн хэлтэс”-ийг шилжүүлж, Орон нутгийн хамгаалалт, улсын дайчилгааны болон Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийг өргөтгөн Орон нутгийн хамгаалалт, дайчилгааны газар, Санхүү, хөрөнгө оруулалтын газар болгон өргөтгөж, Мэдээлэл, технологийн хэлтсийг шинээр байгуулсан;

- Цэргийн алба хаагчийн нийгмийн хамгааллыг сайжруулах, цалин хөлсийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Засгийн газрын тогтоолоор Зэвсэгт хүчин, хилийн цэргийн алба хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг 25 хувь болгон шинэчлэн тогтоож, алслагдсан тооцогдсон цэргийн анги, салбарын алба хаагчид мөнгөн урамшуулал олгох журмыг батлуулсан.

- Төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн дайчилгааны даалгаврын дагуу Төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн дайчилгааны төлөвлөгөөг Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн батлуулсан;

- ҮБХИС-ийн сургалтын тогтолцоо, хөтөлбөрт өөрчлөлт, шинэчлэлт хийж, ҮБХИС-ийн харьяанд “Эрдмийн сургууль”-ийг байгуулж, “Цэргийн нэгдсэн дээд сургууль”-ийг 4 жилийн цэргийн сургалтын тогтолцоонд шилжүүлж, Засгийн газрын тогтоолоор “Батлан хамгаалахын мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв”-ийг “Батлан хамгаалахын политехник коллеж” болгон, БХЭШХ-г БХЯ-ны харьяанд шилжүүлсэн;

- Батлан хамгаалах салбар 2022 оноос Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс, Арабын Нэгдсэн Эмират Улсын батлан хамгаалах яамдтай “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг байгуулж, нийт 39 улстай цэргийн дипломат харилцаа тогтоосон;

- Мөн Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдөр гарын үсэг зурж, Улсын Их Хурлын 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар “Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийг батлуулсан зэрэг юм.

Хэдий ийм боловч батлан хамгаалах үйл ажиллагааны төсөв хязгаарлагдмал, улсын төсвийн хөрөнгө оруулалт бага байсан нь төлөвлөсөн арга хэмжээнүүдийн

хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх гол хүчин зүйл байлаа. Тухайлбал, Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх, шинэчлэн сайжруулах, нөөц бүрдүүлэх, сольж шинэчлэх, шинээр цэргийн анги, салбар байгуулах, шилжүүлэн байрлуулах, албан тушаалын орон сууц барих зэрэг ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхэд ихээхэн төсөв, хөрөнгө шаардлагатай байсан нь хэрэгжилтэд сөргөөр нөлөөлсөн.

Ийнхүү аюулгүй байдлын орчны өөрчлөлт, төрөөс батлан хамгаалах талаар дэвшүүлсэн бодлогын зорилт, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд үндэслэн Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт батлан хамгаалах талаар туссан зорилтуудыг хэрэгжүүлэх, батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлэх, мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх, улс орныг батлан хамгаалах бэлтгэл, Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг дээшлүүлэх, эх оронч үзлийг түгээн дэлгэрүүлэх, батлан хамгаалах төсвийг үе шаттайгаар нэмэгдүүлэх, орчин үеийн зэвсэглэл, тоног төхөөрөмжөөр хангах зэрэг асуудал нь 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг бий болгосон.

Стратеги төлөвлөгөөнд Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудалд хамаарах 8 үндсэн чиг үүргийн 29 дэд чиг үүрэг, 119 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан болно.

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”-ын дагуу Батлан хамгаалах салбарын болон Батлан хамгаалах яамны чиг үүрэгт үндэслэн мандатын шинжилгээг хийсэн.

Мандатын шинжилгээгээр Батлан хамгаалах салбарын эрхлэх асуудал нь 61 хууль, үүнээс шууд хамаарах 24 хуулийн хүрээнд салбарын ерөнхий, үндсэн болон дэд чиг үүргүүдийг дараах байдлаар тодорхойллоо.

Батлан хамгаалахын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		61
Үүнээс	Батлан хамгаалахын хуулийн тоо	24
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо	37
Ерөнхий чиг үүрэг: Улс орныг батлан хамгаалах		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1: Батлан хамгаалах үйл ажиллагааны харилцааг зохицуулах хууль, эрх зүйг шинэчилж, цогц байдлыг хангах	Батлан хамгаалахын хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох	УИХ, ЗГ, ЯАМД, ЗХЖШ, ТЦК-ууд
	Батлан хамгаалах бодлого, стратегийг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах	УИХ, Ерөнхийлөгч, ЗГ, ЗХЖШ
ҮЧҮ-2: Батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлэн, батлан хамгаалахын сөрөн тэсвэрлэх чадавхыг дээшлүүлэх	Батлан хамгаалах боловсролын тогтолцоог хөгжүүлэх	УИХ, ЗГ, ТЗТБ, НЗБ, ЗХЖШ
	Орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлэх	УИХ, ЗГ, ТЗТБ, аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗД, ЗХЖШ

	Нэгдсэн удирдлага, төлөвлөлт бүхий дайчилгааны тогтолцоог бэхжүүлэх	УИХ, ЗГ, ТЗТБ, аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗД, ЗХЖШ
	Батлан хамгаалахын аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх	ЗГ, ЗХЖШ, харьяа байгууллагууд
	Бүсийн сургалтын төвийг байгуулж, "Оюутан цэрэг"-т цэргийн мэргэжил олгох сургалтыг зохион байгуулах	ЗГ, ТЗТБ, аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗД, ЗХЖШ
	Батлан хамгаалах материаллаг нөөцийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, бүрдүүлэх	УИХ, ЗГ, ЗХЖШ
ҮЧҮ-3: Батлан хамгаалахын төсвийн тогтвортой өсөлтийг ханган, технологижсон Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх	Улсын орны эдийн засгийн өсөлттэй уялдуулан төсвийн тогтвортой өсөлтийг хангах	УИХ, ЗГ, ТЗТБ, ЗХЖШ
	Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлж, төрлийн цэргийг хөгжүүлэх	УИХ, ЗГ, СЯ, ЗХЖШ, ТЦК, нэгтгэл, анги, байгууллагууд
	Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогын хэрэгжилтийг хангах	УИХ, ЗГ, СЯ, ЗХЖШ, ТЦК, нэгтгэл, анги, байгууллагууд
	Цэргийн боловсрол, сургалт бэлтгэлийн бодлогыг оновчтой тодорхойлон хэрэгжүүлэх	ЗХЖШ, ТЦК, нэгтгэл, анги, салбар, байгууллагууд
	Энхийг дэмжих ажиллагааны оролцоо, чадавхыг нэмэгдүүлэх	УИХ, ЕТГ, ЗГ, СЯ, ГХЯ, ЗХЖШ
	Зэвсэгт хүчнийг улс орныг хөгжүүлэх бүтээн байгуулалтад оролцуулах	УИХ, ЕТГ, ЗГ, СЯ, ЭЗХЯ, ЗХЖШ
	Алба хаагчдын нийгмийн хамгааллыг дээшлүүлж, алба хаах орчин нөхцөлийг сайжруулах	УИХ, ЗГ, СЯ, ЭЗХЯ, ЗХЖШ
ҮЧҮ-4: Батлан хамгаалахын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх	Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх	УИХ, ЗГ, ГХЯ, ЭСЯ, ЗХЖШ
	Гадаад улс, орнуудтай цэргийн итгэлцлийг бэхжүүлэх арга хэмжээг авах	УИХ, ЗГ, ГХЯ, ЭСЯ, ЗХЖШ
ҮЧҮ-5: Цэргийн шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх	Салбарын шинжлэх ухаан, инновацыг хөгжүүлэх	ЕТГ, ЗГ, ГХЯ, ЗХЖШ, ЭШХ-гүүд
	Орчин үеийн техник, технологи, инновацыг нутагшуулж, цэргийн зарим төрлийн техник, хэрэгслийг эх орондоо үйлдвэрлэх	УИХ, ЕТГ, ЗГ, СЯ, ЭЗХЯ, ЗХЖШ, БХЭШХ
ҮЧҮ-6: Улсын нисэхийг хөгжүүлэх бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, нислэг, нислэгийн аюулгүй байдлыг хангах, эрх зүйг боловсронгуй болгох	Улсын агаарын хөлгөөр нислэг үйлдэх, нислэгийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлыг хангах, улсын агаарын хөлгийг бүртгэх, гэрчилгээжүүлэх, нислэгт тэнцэх чадварыг тодорхойлоход мэргэжлийн дэмжлэг үзүүлэх	Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагууд
	Нисэхийн мэргэжлийн үнэмлэх, зэрэг, зэрэглэл олгох арга хэмжээг	Төрийн цэргийн болон хууль

	хэрэгжүүлэх, баталгаажуулах, нисэхийн мэргэжлийн бэлтгэл, сургалтын үйл ажиллагаанд хяналт тавих, мэргэжлийн дэмжлэг үзүүлэх	сахиулах байгууллагууд
ҮЧҮ-7:Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, иргэдэд эх оронч үзлийг төлөвшүүлэх ажлыг зохион байгуулах	Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх	ЗХЖШ, ТЦК, УГ, нэгтгэл, анги байгууллагууд
	Иргэдэд эх оронч үзлийг төлөвшүүлэх ажлыг зохион байгуулах	ЕТГ, ЗГ, СЯ, БЯ, ЗХЖШ, Соёмбо редакц
	Батлан хамгаалахын мэдээлэл, сурталчилгаа, соёл урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулах	ЕТГ, ЗГ, БЯ, ССАЖЗЯ, ЗХЖШ, ЦДБЭЧ, МЦМ
	Цэргийн насны залуусын эрүүл мэндийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх	ЗГ, ЭМЯ, ЗХЖШ, ЦТЭ
	Архивын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлж, архивын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх	ЗХЖШ, БХТА
ҮЧҮ-8: Салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хяналт шалгалтын бодлого, чиглэлийг тодорхойлж, зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг хэрэгжүүлэх	Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг хэрэгжүүлэх	УИХ, ЗГ, Ерөнхий хянан шалгагч
	Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, төрийн цэргийн байгууллагын батлан хамгаалах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих	ТЗБ, НЗБ, Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагууд
	Батлан хамгаалах салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, эрсдэлийг тооцох, хараат бус дотоод аудит явуулах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах	ЗХЖШ, харьяа байгууллагууд

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Батлан хамгаалах чадавх, тогтолцоог бэхжүүлнэ.

ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

Батлан хамгаалахын сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлж, Зэвсэгт хүчний шинэчлэлийг эрчимжүүлнэ.

ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Орчны шинжилгээ стратегийн шийдвэр гаргахад удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангах зорилгоор Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Төрлийн цэргийн командлал, нэгтгэл, анги, салбар, байгууллага нь бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, хуулиар хүлээлгэсэн чиг үүргийг биелүүлэхэд чиглэсэн зорилтыг хэрэгжүүлэх боломжийг гадаад ба дотоод орчны хүчин зүйлийн хүрээнд тулгуурлан дараах байдлаар тодорхойлсон болно.

5.1. Гадаад орчны шинжилгээ:

Гадаад орчны шинжилгээг хийхдээ аюулгүй байдлын орчин, улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, технологи, хууль эрх зүй, байгаль орчны зүгээс үзүүлэх нөлөөлөл, эерэг боломж, сөрөг нөлөөлөл, үүсэж болох эрсдэлийг тооцсон.

5.1.1. Аюулгүй байдлын орчинд хийсэн шинжилгээ /ОХУ, БНХАУ/:

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС	
Давуу тал:	Сул тал:
- Батлан хамгаалах харилцааг бэхжүүлэн хөгжүүлснээр Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах нөхцөл боломж бүрдэж, баталгаа бий болно; - Монгол Улсын Зэвсэгт хүчний зэвсэглэл, техникийг шинэчилж, сайжруулах, зэвсэглэл, техникийн сэлбэг, галт хэрэглэл, түлш шатахууны хангалт авах, цэргийн мэргэжилтэн бэлтгэх таатай нөхцөл, боломж бүрдэнэ; - ОХУ-ын нутаг дэвсгэрийг давж гуравдагч улс, хүчнээс цэргийн аюул, занал үүсэх нөхцөл боломж хязгаарлагдмал.	- ОХУ-ын нөлөө, бүс нутгийн бодлогын хүрээнд автаж, эдийн засгийн хараат байдалд байна; - Монгол Улсаас гадаадад гаргах бүтээгдэхүүн ОХУ-ын нутгаар дамжин гарах учир тээвэрлэлт, татварын дарамт хөрш улсын зүгээс байнга учирна; - Монгол Улсын гадагшаа урсдаг ихэнх гол мөрнүүд (Хэрлэн голоос бусад) нь ОХУ-ын нутаг руу гардгаас тэдгээр гол мөрнийг эрчим хүчний эх үүсвэр болгон ашиглах боломжийг ОХУ-ын зүгээс олон улсын хуульд дулдуйдан хязгаарладаг; - Гадаадын бусад улстай цэргийн болон цэрэг-техникийн хамтын ажиллагааг хөгжүүлэх боломж хязгаарлагдмал, цэргийн зориулалттай бүтээгдэхүүн гуравдагч улсаас авах боломжийг хязгаарладаг.
Боломж:	Аюул занал:
- Хоёр улс хөрш зэргэлдээ оршиж газар нутгийн хувьд нийлсэн байдал нь тус улсаас хэрэгцээт бараа бүтээгдэхүүний хангалтыг түргэн шуурхай авах; - Монгол Улс эдийн засгийн салбарууд, аж үйлдвэрээ хөгжүүлж, олон улсад өрсөлдөх чадвартай экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх тохиолдолд ОХУ нь том зах зээл байх; - Монгол Улс өөрийн бараа бүтээгдэхүүнээ ОХУ-ын нутгаар дамжуулан тэдний тээврээр гуравдагч улсад гаргах зэрэг болно.	- ОХУ стратегийн ач холбогдол бүхий чухал бүтээгдэхүүний нийлүүлэлтээ хязгаарлах, нийлүүлэхээс татгалзах нь Монгол Улсыг хямралт байдалд хүргэнэ; - ОХУ-ын дотоод нөхцөл байдал хурцадвал түүнээс шалтгаалж үндсэрхэг үзэл, шашин, хэт даврах үзэл, терроризмын аюултай бүлэглэл, түүнтэй тэмцэх хүчин, дүрвэгсэд Монгол Улсын нутагт орж ирж болзошгүй.
БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС	
Давуу тал:	Сул тал:
- Батлан хамгаалахын харилцаа нь хоёр улсын Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны чухал бүрэлдэхүүн хэсэг болдог;	- Манай улсын зүгээс АНУ-тай явуулж байгаа цэргийн хамтын ажиллагааны идэвхжилтэд эмзэг ханддаг; - Эдийн засаг, худалдааны хувьд Хятадаас хамааралтай байна;

- Батлан хамгаалах салбарт харилцааг хөгжүүлснээр цэргийн итгэлцэл, улс төрийн харилцан ойлголцол нэмэгдэх; - Цэргийн буцалтгүй тусламж нь Зэвсэгт хүчний шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд манай цэргийн алба хаагчдын нийгмийн хамгааллыг дээшлүүлэх, улс орны бүтээн байгуулалтад чухал хувь нэмэр оруулдаг.	- Гадаад худалдааны дамжин өнгөрөх тээврийн нөхцөлөөс хараат байна; - Хятадын эсрэг үзэл Монголд түгээмэл байна; - Үндэсний ашиг сонирхлын зөрүүтэй байдал байсаар байна. Тухайлбал, Далай ламын асуудал.
Боломж:	Аюул занал:
- Хоёр талын зэвсэг, техникийн хамтын ажиллагааны эхлэл тавигдсан бөгөөд цаашид өргөжүүлэх; - Хоёр талын хамтарсан хээрийн сургуулийг анхлан хийж эхэлсэн ба хилийн чанадад Энхийг дэмжих ажиллагааны болон Терроризмын чиглэлээр хамтарч ажиллах зэрэг болно.	- Тус улс 2049 онд үндэсний их цэцэглэлтэд хүрэхийн тулд эдийн засаг, нийгэм, улс төр, цэрэг-аюулгүй байдлын салбарын хөгжүүлэх хүрээнд цэргийн шинэчлэл, батлан хамгаалах салбарынхаа хөгжлийг өргөн хүрээнд авч үзэж байна; - Хил залгаа ШУӨЗО-ноос террорист халдлага үйлдэгдэх, дотоодод нийтийг хамарсан гамшиг учирвал дүрвэгсэд хил давж орж ирэх аюул, занал үүсэж болзошгүй.

5.1.2. Аюулгүй байдлын орчинд хийсэн шинжилгээ /Гуравдагч хөрш АНУ, Япон Улс, БНСУ/:

АМЕРИКИЙН НӨГДСӨН УЛС	
Давуу тал:	Сул тал:
- Хоёр хөршийн цэрэг, улс төр, эдийн засгийн нөлөөг бууруулна; - Энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлогоо улс төр-дипломатын арга замаар хэрэгжүүлэхэд АНУ-тай олон талаар хамтран ажиллах боломжтой, суурь түвшин бүрдсэн; - Батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлэхэд бодит дэмжлэг үзүүлнэ; - Цэрэг, стратегийн хувьд туршлага солилцох, боловсрол, техникийн дэмжлэг авна.	- Хоёр улсын цэргийн хамтын ажиллагааны идэвхжилд ОХУ, БНХАУ-ын зүгээс эмзэг ханддаг тул хоёр хөршийн манай улстай харилцах харилцаанд нөлөөлж болзошгүй; - Цэрэг, техникийн тусламж авах боломж хязгаарлагдмал; - Их гүрнүүдийн цэрэг, улс төр, эдийн засгийн нөлөө ирэх магадлал өндөр; - Зэвсэглэл, техникийн хөгжил асар их зөрүүтэй байдалтай.
Боломж:	Аюул занал:
- Батлан хамгаалах хамтын ажиллагааны хүрээнд уламжлалт хэлбэрийг хадгалахын зэрэгцээ шинэ чиглэлийг өргөжүүлэх гарцыг бий болгох; - Энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт улс төр-дипломатын үйл ажиллагаагаар аюулгүй байдлаа бэхжүүлэх; - Зэвсэгт хүчний төрлийн цэргийг хөгжүүлэхэд хамтрах;	- БНХАУ, АНУ, ОХУ хоорондын өрсөлдөөн, нэг нэгнээ хазаарлах оролдлогууд нь худалдааны дайнаас халин аюулгүй байдлын нөлөөний бүсээ хуваах чиглэлд шилжвэл Монгол Улсын гадаад бодлого, аюулгүй байдалд томоохон сорилт учруулж болзошгүй; - Их гүрнүүдийн улс төр, эдийн засгийн дарамт, хөрш орнуудын шахалт, нөлөө ихсэх магадлалтай.

- Мэргэжлийн Зэвсэгт хүчнийг чадавхжуулах; - Орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр ЭДА-нд оруулж буй цэргийн багийг хангуулах; - Бие бүрэлдэхүүний боловсролын түвшинг дээшлүүлэхэд хамтрах.	
ЯПОН УЛС	
Давуу тал:	Сул тал:
- Гуравдагч хөршийн бодлогоор дамжуулан Үндэсний аюулгүй байдлаа баталгаажуулна; - Монгол, Японы стратегийн түншлэлийн харилцаанд батлан хамгаалах харилцаа, хамтын ажиллагаа чухал хувь нэмэр оруулж, түлхэц үзүүлж байна; - Тус улсын БХЯ-наас "Чадавхыг дээшлүүлэх хөтөлбөр"-ийн хүрээнд хэрэгжүүлж байгаа цэргийн инженерийн сургалт, дадлага нь Зэвсэгт хүчний зам, барилгын салбаруудын чадавхыг нэмэгдүүлнэ; - Монгол Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгүүлэх "Барилга инженерийн рот"-ын бэлтгэлийг хангах, тус ротын үндсэн мэргэжилтэн бэлтгэгдэх чухал ач холбогдолтой.	- Япон Улс, АНУ зэрэг гуравдагч хөрштэй явуулж буй цэргийн хамтын ажиллагааны идэвхжилтэд Хятадын тал эмзэг ханддаг тул тус улсын зүгээс дарамт, шахалт, нөлөө ихсэх магадлалтай; - Монгол Улсын зах зээл жижиг, далайд гарцгүй, хоёр их гүрнээс хамааралтай ч байгалийн асар их баялагтай тооцогддог нь Япон Улсын хувьд урт хугацаанд нөөцөө баталгаажуулж авах бодлогын нэг субъект нь манай улс байж болох талтай.
Боломж:	Аюул занал:
- НҮБ-ын энхийг дэмжих ажиллагааны чиглэлээр харилцан туршлага солилцох, цаашид НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд хамтран оролцох; - Монгол Улсын Зэвсэгт хүчний чадавхыг дээшлүүлэх хөтөлбөрийг цэргийн инженер, агаарын цэргийн чиглэлд өргөжүүлэх; - Гамшгаас хамгаалах, хүмүүнлэгийн тусламж, чадавхыг нэмэгдүүлэхэд хамтран ажиллах, туршлага, сургамжаас суралцах; - Цэргийн судалгааны байгууллага хооронд хамтран ажиллах, шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэх.	- Япон Улсын зүгээс шууд учрах цэргийн аюул байхгүй ч хөгжингүй улс орнуудын өрсөлдөөн, нэг нэгнээ хазаарлах оролдлогууд нь манай улсын гадаад бодлого, аюулгүй байдалд томоохон сорилт учруулж болзошгүй.
БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС	
Давуу тал:	Сул тал:
- Батлан хамгаалахын харилцаа нь харилцан айлчлал хийх, цэргийн бүх түвшний төлөөлөгч солилцох, БХЯ-д хоорондын зөвлөлдөх уулзалт хийх,	- Эдийн засгийн хувьд манай хүн ам цөөн тул зах зээл жижиг, ОХУ, БНХАУ-ын хамаарал ихтэй;

цэргийн мэргэжилтэн харилцан сургаж бэлтгэх, хамтарсан сургалт дадлага явуулах, олон улсын хурал, семинар, үзэсгэлэн арга хэмжээнд харилцан урьж оролцуулах зэрэг чиглэлээр идэвхжиж байна; - Хоёр улсын гадаад харилцааны хувьд чөлөөтэй, олон улстай найрсаг хамтын ажиллагаатай; - Гадаад улсуудын аюул занал байхгүй харьцангуй тайван улсуудын тоонд зүй ёсоор багтдаг.	- Монгол Улсын байгалийн баялаг, БНСУ-ын менежмент, технологи, хөрөнгө оруулалт зэргийг нэгтгэн хамтран ажиллаж чадахгүй байна; - Дэлхийн эдийн засгийн өсөлт удааширч нефть болон бусад ашигт малтмалын үнэ унаснаар нэг талдаа ихэнх түүхий эдээ гаднаас авдаг БНСУ-ын худалдааны тэнцэлд манай улс ашигтай байх талтай.
Боломж: - Монгол Улсын цэргийн алба хаагчдыг БНСУ-ын цэргийн их, дээд сургуульд болон богино хугацааны сургалтад үргэлжлүүлэн суралцуулах; - Хамтарсан хээрийн сургуулийг тогтмолжуулах, хиймэл оюун ухаан, нисгэгчгүй нисэх хэрэгслийн хүрээнд хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх, эрдэм шинжилгээний байгууллагуудын хамтын ажиллагааг идэвхжүүлэх талаар ажиллах; - Худалдааны харилцаа нь хоёр хөршийн эдийн засгийн нөлөөг саармагжуулах, нэг улсаас хараат байдлыг багасгах, бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдэн орох, олон улсад өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх; - БНСУ-ын буцалтгүй тусламжийн үр өгөөжийг дээшлүүлэх; - Олон талт, бүс нутгийн хамтын ажиллагааны санал, санаачилгыг дэмжиж, хамтран ажиллах; - Солонгосын хойг, Зүүн хойд Азийн бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн хамтын ажиллагааг идэвхжүүлэх.	Аюул занал: - Солонгосын хойгт цөмийн зэвсгийн аюул оршин байгаа бөгөөд нөхцөл байдлыг хүчээр, өөрчлөх гэсэн оролдлого нь асуудлыг улам хурцатгах төдийгүй, бүс нутгийг бүхэлд нь хамарсан зэвсэгт мөргөлдөөнд хүргэх аюултай; - Нөхцөл байдал хүндэрсэн үед Умард Солонгосоос дүрвэгчид орж ирэх магадлалыг нэмэгдүүлнэ; - Бүс нутагт их гүрнүүдийн нөлөөллийн төлөөх өрсөлдөөн байгаа нь манай улсын гадаад бодлого, аюулгүй байдалд сорилт учруулна.

5.1.3. Дэлхийн болон бүс нутгийн хамтын нийгэмлэгийн байгууллагуудад хийсэн шинжилгээ /НҮБ, НАТО/:

НЭГДСЭН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГА	
Давуу тал:	Сул тал:
- Манай Зэвсэгт хүчин анх 2002 онд НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлснээс хойших 22 жилийн хугацаанд 22000 гаруй цэргийн алба хаагчийг оролцуулж байна; - Монгол Улсын батлан хамгаалах бодлогод НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаа болон олон улсын цэргийн	- НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцоогоо нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд хөрөнгө санхүүгийн хувьд хязгаарлагдмал байдлаас үүдсэн хүндрэл, бэрхшээл учирч байна.

ажиллагаанд өөрийн хувь нэмрийг оруулах явдал чухал байр суурь эзэлдэг; - Өөрийн аюулгүй байдлыг хангах, олон улсын түвшинд Монгол Улсын байр суурийг бэхжүүлэх, Зэвсэгт хүчний чадавхыг нэмэгдүүлэх, зэвсэглэл, техникийн шинэчлэлийг хийхэд чухал ач холбогдолтой.	
Боломж:	Аюул занал:
- Монгол Улсын Зэвсэгт хүчин Тусгай хүчний рот, Инженерийн рот, Цэргийн эмнэлгийн салбарыг энхийг сахиулах ажиллагаанд оролцуулах бэлтгэлийг дуусгаж, шинээр оролцуулж эхлэх; - Монгол Улс НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх ЦАХ-дын үндсэн үүргээ гүйцэтгэх ур чадвар нэмэгдэх, олон улсын түвшинд цэргийн ажиллагаанд оролцох туршлага хуримтлуулах.	- НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож буй цэргийн багийн бие бүрэлдэхүүн аюулгүй байдлын эрсдэлийн өндөр түвшинд үүрэг гүйцэтгэдэг; - Цагийн байдлын хувьд тухайн улс орны улс төрийн тогтворгүй байдал, зэвсэгт бүлэглэлүүдийн хоорондох мөргөлдөөн идэвхжих, орон нутгийн сонгууль болох үед цагийн байдал хурцдаж, халдлага дайралтад өртөх магадлал ихэсдэг.
УМАРД АТЛАНТЫН ГЭРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА /НАТО/	
Давуу тал:	Сул тал:
- 2024 онд "Монгол Улс, НАТО хоорондын түншлэл, хамтын ажиллагааны хөтөлбөр"-ийг "Тусгайлсан түншлэлийн хөтөлбөр" болгон шинэчлэн баталснаар дараах давуу талыг бий болгож байна: - НАТО-гийн өндөр, дээд хэмжээний чуулга уулзалт, НАТО-гийн Парламентын Ассамблейн хуралдаануудад Монгол Улсын төлөөллийг оролцуулах; - Улс төр, олон улс болон бүс нутгийн аюулгүй байдал, батлан хамгаалах асуудлаар зөвлөлдөх уулзалт хийх, НАТО-гийн төрөл мэргэжлийн бага хурал, сургалт, семинарт хамрагдах; - НАТО-гоос зохион байгуулдаг төрөл бүрийн сургалт, дамжаа, сургууль, дадлагад ЦАХ-чдын оролцуулах, тоог нэмэгдүүлэх зэрэг болно.	- ОХУ, Украины дайнтай холбоотой ОХУ Европ, АНУ, НАТО-тай, Солонгосын Хойг, Өмнөд Хятадын тэнгисийн хямрал, худалдааны маргаан зэрэг асуудлаас үүдэлтэйгээр АНУ БНХАУ-тай сөргөлдсөн, үл ойлголцсон байдал нь хоёр хөрштэй Монгол Улсын НАТО-тай харилцах харилцаанд зарим талаар сөргөөр нөлөөлөх магадлалтай.
Боломж:	Аюул занал:
- НАТО-гийн гишүүн болон түнш орнуудтай адил түвшинд яриа, хэлэлцээр хийх, тэдгээртэй улс төр, эдийн засаг, эрдэм шинжилгээ, судалгаа, цэргийн чиглэлээр харилцаагаа өргөжүүлэх;	- Манай улс НАТО-той түнш орны статустайгаар харилцаж байгаа нь зарим тохиолдолд хоёр хөрш орны зүгээс дургүйцлээ илэрхийлэх, харилцааг өргөжүүлэхийг зохимжтой бус гэж үзэх магадлалтай.

- НАТО-гийн иргэний болон цэргийн мэргэжлийн чиглэлийн сургалт, сургууль болон бусад арга хэмжээнд оролцох, алба хаагчид өөрийн мэдлэг чадвараа дээшлүүлэх; - Монгол Улсын төрийн байгууллагуудад шаардлагатай чиглэлээр төрөл бүрийн төсөл, хөтөлбөр хамтран хэрэгжүүлэх; - Монгол Улсын "гуравдагч" хөршийн бодлогыг хэрэгжүүлэх; - НАТО-гийн "Аюулгүй байдал, энхийн төлөө шинжлэх ухаан" хөтөлбөрийн хүрээнд "Кибер аюулгүй байдлын төв байгуулах.	
---	--

5.1.4. Гадаад орчны шинжилгээ /улсын хэмжээнд/:

Орчны хүчин зүйл	Үзүүлэх нөлөөлөл
Улс төр	Энхийг дэмжих ажиллагаанд оролцох, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлснээр Монгол Улсын гадаад орчны таатай байдлыг бүрдүүлэх, гадаадын зээл, тусламжийг нэмэгдүүлэх, аюулгүй байдлаа улс төр, дипломатын аргаар хангах зорилтыг хэрэгжүүлэх, хөрш орнуудтай олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх, бүс нутагт цэргийн итгэлцлийг бэхжүүлэхэд эергээр нөлөөлнө. - Улс төрийн үйл ажиллагаа батлан хамгаалах, зэвсэгт хүчний хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ.
Эдийн засаг	- Батлан хамгаалах арга хэмжээний зардлыг улсын төсвөөс болон хуульд заасан эх үүсвэрээс санхүүжүүлж байгаа нь батлан хамгаалах, зэвсэгт хүчний хөгжилд нөлөөлнө. - Монгол Улсын эдийн засгийн өсөлтөөс батлан хамгаалахын хөрөнгө оруулалтын зардлын хэмжээ шууд хамаарна. - Монгол Улсын төсөвт Батлан хамгаалах зардлын эзлэх хувь, хөрөнгө оруулалтын зардлын хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэхгүй нөхцөлд хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан үндсэн чиглэлүүдийг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүснэ. - Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангах стратегийн ач холбогдолтой томоохон бүтээн байгуулалтад Зэвсэгт хүчнийг оролцуулснаар улс орны эдийн засгийн өсөлтийг дэмжинэ. - Батлан хамгаалахын эрдэм судлал, цэргийн зэвсэглэл, техник, технологийн шинэчлэл нь өндөр бүтээмжтэй, дэвшилтэт технологийг салбар бүрт нэвтрүүлэх, инновац шингэсэн шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих урт хугацааны бодлогод нийцэж, төрөөс батлан хамгаалах салбарт үзүүлэх эдийн засгийн хөрөнгө оруулалт, төсвийн эзлэх хувь, хэмжээ өснө. - Инженерийн боловсрол бүхий цэргийн дээд мэргэжилтэй алба хаагчид, Зэвсэгт хүчний барилга-инженерийн ангиуд уул уурхай, барилга, хот байгуулалт, дэд бүтэц, газрын хэвлийн

	нөхөн сэргээлтийн салбарт бүтээн байгуулалтын ажилд оролцох нь эдийн засгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ.
Нийгэм соёл	- Нийгэм соёлд үзүүлэх нөлөөлөл нь урт хугацааны байх бөгөөд хүн ам зүйн байдал, эдийн засаг, нийгмийн хөгжлөөс шууд хамаарна. - Хүн амын эрүүл мэнд, боловсрол, амьдралын чанар нь Зэвсэгт хүчнийг мэргэжлийн, чадварлаг бүрэлдэхүүнээр хангах хүний нөөцийн бодлого, зорилтод шууд нөлөөлнө. - Стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ нь зорилтот бүлгийн эрх ашиг, хариуцлагыг хөндөхгүй. - Хүүхэд, залуучуудын эх оронч хүмүүжил, төлөвшилд ахиц гарч, тэдний бие бялдар, сэтгэл зүй, хандлагад эерэг өөрчлөлт бий болно. - Иргэдийн эх оронч хүмүүжил, түүх, уламжлал, төрийн цэргийн байгууллагуудын алба хаагчдыг хүндлэх, Үндсэн хуулиар тогтоосон үндсэн болон журамт үүргийг хэрэгжүүлэх ойлголт, хандлага дээшилнэ. - Цэргийн нэгтгэл, анги, байгууллага үйл ажиллагаа явуулж буй орон нутагт ажлын байр нэмэгдэж, анги, байгууллагуудын спорт, соёл урлаг, сургалтын байгууламж нь орон нутгийн иргэдийн төрийн үйлчилгээ авах, амралт, соёлыг түгээх, төр, иргэний харилцан ажиллагаа нэмэгдэх нөхцөл болно.
Технологи	- Цэргийн шинжлэх ухаан, технологи, цэргийн зэвсэглэл, техникийн шинэчлэл нь улс оронд өндөр бүтээмжтэй, дэвшилтэт технологийг нэвтрүүлснээр тодорхойлогдож, инновац шингэсэн шинэ нэр, төрлийн цэргийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд нөлөөлнө. - Технологийн хурдацтай хувьсал, гаднаас хараат байдал нь зэвсэглэл, техникийн шинэчлэлийн эрчимд нөлөөлнө.
Хууль эрх зүй	Хууль эрх зүйн орчны нөлөөлөл нь батлагдан гарсан хууль, эрх зүйн баримт бичгүүдэд батлан хамгаалах эрх ашгийг хэрхэн тусгаснаас шууд хамаарна. Батлан хамгаалахын багц хуулийн шинэчлэлт, бодлогын тогтвортой байдал нь батлан хамгаалах хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ. Улс орноо батлан хамгаалахад дараах хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдийг голлон мөрдөж байна: - Монгол Улсын Үндсэн хууль; - Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал; - Гадаад бодлогын үзэл баримтлал; - Алсын хараа-2050; - Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс; - Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль; - Зэвсэгт хүчний тухай хууль - Цэргийн албаны тухай хууль - Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль - Дайны байдлын тухай хууль - Гадаадын цэргийн хүчнийг байрлуулах, дамжин өнгөрүүлэх тухай хууль - Дайчилгааны тухай хууль - Орон нутгийн хамгаалалтын тухай хууль

	- Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль - Төрийн албаны тухай хууль - Төсвийн тухай хууль - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль - Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
Байгаль орчин	- Монгол орны байгаль орчин, уур амьсгал батлан хамгаалах, зэвсэгт хүчний үйл ажиллагаанд төдийлөн нөлөөлөхгүй. - Зэвсэглэл, цэргийн техникийн хадгалалт, хамгаалалтад уур амьсгалын нөхцөл тодорхой хэмжээгээр нөлөөлнө.

5.1.5. Дотоод орчны шинжилгээ:

Дотоод орчны шинжилгээг хийхдээ байгууллагын тогтолцоо, нөөц (хүн, санхүү, мэдээллийн технологи) зэрэг хүчин зүйлсийн хүрээнд тодорхойллоо.

Орчны хүчин зүйл	Үзүүлэх нөлөөлөл
Байгууллагын тогтолцоо	- Стратеги төлөвлөгөөг одоо мөрдөж буй байгууллагын тогтолцоогоор хэрэгжүүлэх боломжтой. - Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, хяналт тавих, захиргааны үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулалтын бүтэц, нэгжүүдийн чиг үүрэгт хязгаарлагдмал хүрээнд өөрчлөлт хийгдэж болно. - 2020 онд Зэвсэгт хүчний бүтцэд төрлийн цэргийн командлалуудыг шинээр байгуулсантай холбоотойгоор тус тогтолцоог бэхжүүлэх, хөгжүүлэх, шинээр цэргийн анги, төвүүд байгуулах ажил үргэлжилнэ. - Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад аливаа нэгэн байгууллагыг татан буулгах шаардлага үүсэхгүй.
Хүний нөөц	- Жил бүр дотоод, гадаадын их, дээд сургууль, дамжааг 1500-2000 офицер, ахлагч төгсөж байна. - Батлан хамгаалах яам, харьяа байгууллагын хүний нөөцийн хангалт 75.5 хувьтай, ЗХЖШ, командлалууд, нэгтгэл, анги, салбарын хүний нөөцийн хангалт 60 орчим хувьтай байна. - Хүний нөөцийн төлөвлөлт, нэгдсэн санд өөрчлөлт оруулах шаардлага гарна. - Зэвсэгт хүчний цэргийн мэргэжлийн бүрэлдэхүүний ангилал, албан тушаалын шаардлага, мэргэжил, мэргэшлийн шалгуур үзүүлэлтэд өөрчлөлт оруулж болно.
Санхүүгийн нөөц	- Батлан хамгаалах улсын төсвийн хувь, хөрөнгө оруулалтын хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэхгүй нөхцөлд хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан үндсэн чиглэлүүдийг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүсэх магадлалтай. - Эдийн засгийн өсөлтийн хувь хэмжээнээс хамаарч батлан хамгаалахын хөгжлийн өндөр төсөв, өртөг бүхий бодлогын төсөл, арга хэмжээ нь эргээд төр, засагт дарамт учруулж болзошгүй. - Батлан хамгаалах аж үйлдвэрлэлийн сул хөгжил нь батлан хамгаалахын хөгжлийн бодлогын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж, төсвийн болон гадаад улсын техник, технологийн тусламж, хандиваас шууд хараат байдлыг нэмэгдүүлнэ.

Мэдээллийн технологийн нөөц	- Төрөөс төрийн үйлчилгээг цахимжуулах, e-mongolia төсөл, мэдээллийн ил тод байдлыг хангах үйл ажиллагаа нь байгууллагын үйл ажиллагааны онцлог, мэдээллийн нууцын шаардлагад нөлөөлнө. - Батлан хамгаалах яамны дотоод мэдээлэл солилцох систем /Microsoft Exchange Server 2010/, дайчилгааны мэдээллийн сан, бичиг хэргийн бүртгэлийн систем, байгууллагын цахим архив, Cloud university оюутны цахим систем, Medsoft эмнэлгийн мэдээллийн систем, ВЕБ хуудсыг өнөөгийн байдлаар сүлжээнд хэрэглэж байна. - Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан мэдээллийн сүлжээг нэвтрүүлэх шаардлага үүснэ.
------------------------------------	--

5.1.6. Орчны шинжилгээний үр дүн:

Гадаад ба дотоод орчны зүгээс нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлсны үндсэн дээр орчны шинжилгээний үр дүнг CBOT (Strengths, Weaknesses, Opportunities, Threats) хүснэгтэд дараах байдлаар нэгтгэн харууллаа.

Орчны шинжилгээний үр дүн ДОТООД ОРЧИН

Давуу тал	Сул тал
- Стратеги төлөвлөгөөг байгууллагын тогтолцоогоор хэрэгжүүлэх боломжтой. Зэвсэгт хүчний бүтцэд төрлийн цэргийн командлалуудыг шинээр байгуулсан нь бүтцийн өөрчлөлтийг дахин хийхгүй. - Жил бүр дотоод, гадаадын их, дээд сургууль, дамжааг 1500-2000 офицер, ахлагч төгсөж байна. - Батлан хамгаалах яам, харьяа байгууллагын хүний нөөцийн хангалт 85 орчим хувь бол ЗХЖШ, командлалууд, нэгтгэл, анги, салбарын хүний нөөцийн хангалт 60 гаруй хувьтай байна. - Хүний нөөцийн төлөвлөлтөд урт хугацаанд тодорхой өөрчлөлт оруулна. - Батлан хамгаалах яамны дотоод мэдээлэл солилцох систем /Microsoft Exchange Server 2010/, дайчилгааны мэдээллийн сан, бичиг хэргийн бүртгэлийн систем, байгууллагын цахим архив, Cloud university оюутны цахим систем, Medsoft эмнэлгийн мэдээллийн систем, ВЕБ хуудсыг өнөөгийн байдлаар сүлжээнд хэрэглэж байна.	- Зэвсэгт хүчний бүтцэд төрлийн цэргийн командлалуудыг шинээр байгуулснаар тус бүтцийг бэхжүүлэх, хөгжүүлэх, шинээр цэргийн анги, төвүүд байгуулах шаардлага үүснэ. - Шинээр байгуулах бүтэц, орон тооны өөрчлөлтөөс шалтгаалан бодлогын төсөл, арга хэмжээ нь төрд төсвийн дарамт учруулж болзошгүй. - Мөн эдийн засгийн өсөлтийн хувь хэмжээнээс хамаарч цэргийн хөгжлийн өндөр төсөв, өртөг бүхий бодлогын төсөл, арга хэмжээ нь эргээд төр, засагт дарамт учруулж болзошгүй. - Батлан хамгаалах аж үйлдвэрлэлийн сул хөгжил нь батлан хамгаалах хөгжлийн бодлогын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж, төсвийн болон гадаад улсын техник, технологийн тусламж, хандиваас шууд хараат байдлыг нэмэгдүүлнэ.
ГАДААД ОРЧИН	
Боломж	Эрсдэл
- НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын цэргийн ажиллагаанд оролцох, гадаад хамтын ажиллагааг	- Улс орны эдийн засгийн боломж, чадавхаас батлан хамгаалахын хөрөнгө оруулалт, зардлын хэмжээ шууд

хөгжүүлснээр Монгол Улсын гадаад таатай орчныг бүрдүүлэх, гадаадын зээл, тусламжийг нэмэгдүүлэх, аюулгүй байдлаа улс төр, дипломатын аргаар хангах зорилтыг хэрэгжүүлэх, хөрш орнуудтай олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх, бүс нутагт цэргийн итгэлцлийг бэхжүүлэхэд эергээр нөлөөлнө. - Инженерийн боловсрол бүхий цэргийн дээд мэргэжилтэй алба хаагчид, Зэвсэгт хүчний барилга-инженерийн ангиуд уул уурхай, барилга, хот байгуулалт, дэд бүтцийн салбарт бүтээн байгуулалтын ажилд оролцох нь эдийн засгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ. - Хүүхэд, залуучуудын эх оронч хүмүүжил, төлөвшилд ахиц гарч, тэдний бие бялдар, сэтгэл зүй, хандлагад эерэг өөрчлөлт бий болно. - Иргэдийн эх оронч хүмүүжил, түүх, уламжлал, төрийн цэргийн байгууллагуудын алба хаагчдыг хүндлэх, Үндсэн хуулиар тогтоосон үндсэн болон журамт үүргийг хэрэгжүүлэх ойлголт, хандлага дээшилнэ. - Цэргийн нэгтгэл, анги, байгууллага үйл ажиллагаа явуулж буй орон нутагт ажлын байр нэмэгдэж, анги, байгууллагуудын спорт, соёл урлаг, сургалтын байгууламж нь орон нутгийн иргэдийн төрийн үйлчилгээ авах, амралт, соёлыг түгээх, төр, иргэний харилцан ажиллагаа нэмэгдэх нөхцөл болно. - Батлан хамгаалахын багц хуулийн шинэчлэлт, бодлогын тогтвортой байдал нь түүний хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ.	хамаарч байгаа нь батлан хамгаалах төсвийн хувь, хөрөнгө оруулалтын хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэхгүй нөхцөлд хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан үндсэн чиглэлүүдийг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүснэ. - Хүн амын эрүүл мэнд, боловсрол, амьдралын чанар нь Зэвсэгт хүчнийг мэргэжлийн, чадварлаг бүрэлдэхүүнээр хангах хүний нөөцийн бодлого, зорилтод шууд нөлөөлнө. - Технологийн хурдацтай хувьсал, гаднаас хараат байдал нь батлан хамгаалахын зэвсэглэл, техникийн шинэчлэлийн эрчимд нөлөөлнө. - Хууль эрх зүйн орчны нөлөөлөл нь батлагдан гарсан хууль эрх зүйн баримт бичгүүдэд батлан хамгаалах эрх ашгийг хэрхэн тусгаснаас шууд хамаарна. - Зэвсэглэл, цэргийн техникийн хадгалалт, хамгаалалтад уур амьсгалын нөхцөл байдал тодорхой хэмжээгээр нөлөөлнө. - Дэлхий, бүс нутгийн геополитик болон геостратегийн огцом өөрчлөлт, их гүрнүүдийн ашиг сонирхолын сөргөлдөөн, хөрш орнуудын нийгэм, эдийн засаг, аюулгүй байдлын баримтлаж буй бодлого нь Монгол Улсын хөгжил, Үндэсний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай.
--	--

**БАТЛАН ХАМГААЛАХЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ
(2025-2028 он)**

ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТАЛСАН:
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД



ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ

С.БЯМБАЦОГТ

2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
БРИГАДЫН ГЕНЕРАЛ

A handwritten signature in black ink, belonging to D. Ganxuyag.

Д.ГАНХУЯГ

2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр

УЛААНБААТАР
2025 он

ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Монгол Улсын батлан хамгаалах сэргэлтийг эрчимжүүлж, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх бүхий батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн цэрэгт суурилсан, чадварлаг Зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ.

ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОТ ТҮВШИН, СТРАТЕГИ

Бодлогын баримт бичигт тусгагдсан болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Санхүүгийн эх үүсвэр /сая.төг/
1	2	3	4	5	6
ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ: УЛС ОРНЫГ БАТЛАН ХАМГААЛАХ					
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ-1. БАТЛАН ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙГ ШИНЭЧИЛЖ, ЦОГЦ БАЙДЛЫГ ХАНГАХ					
Зорилт 1. Батлан хамгаалахын хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох	1.Батлан хамгаалах салбарын зарим хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах	Хуулийн тоо	6 хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулсан.	6 хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.	-
	2.Хууль тогтоомж, бодлогын баримт бичигт нийцүүлэн цэргийн удирдлага, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах	Баримт бичгийн тоо	Нийт 16 бодлого, дүрэм, журам, заавар, чиглэл боловсруулсан.	17 баримт бичгийг боловсруулж, батлуулсан байна.	-
Зорилт 2. Батлан хамгаалах бодлого, стратегийг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах	1.Үндэсний сөрөн тэсвэрлэх стратегийг боловсруулах, хэрэгжилтийг хангах	Хэрэгжилтийн хувь	-	Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг сайжруулах стратеги, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулсан байна. Салбарын арга хэмжээг 100 хувь хэрэгжүүлсэн байна.	20,000.00 УТ, 3ХХС

	2.Төрийн бодлого, шийдвэрт батлан хамгаалах эрх ашигт нийцсэн бодлого, зорилтыг тусгуулах	Боловсруулсан саналын тоо	ЗГҮАХ-т 10 зорилт, 52 арга хэмжээг тусгуулсан.	- Улсыг хөгжүүлэх дунд, богино хугацааны хөгжлийн төлөвлөлтөд батлан хамгаалах чиглэлээр санал боловсруулж, тусгуулсан байна.	-
	3.Төрийн захиргааны төв болон Нутгийн захиргааны байгууллагын дайчилгааны төлөвлөгөөг шинэчлэх	Төлөвлөгөөний тоо	Дайчилгааны даалгаврууд батлагдсан.	Тухайн байгууллагуудын дайчилгааны төлөвлөгөө 100 хувь шинэчлэгдсэн байна.	-
	4.Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулах	Батлагдсан төлөвлөгөөний тоо	"Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлого батлагдсан.	Төлөвлөгөө батлагдан, хэрэгжилт 20 хувьд хүрсэн байна.	УТ, ЗХХС, Зээл тусламж
	5.Зэвсэгт хүчнийг 2028 он хүртэл хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлуулах	Батлагдсан төлөвлөгөөний тоо	-	Төлөвлөгөө батлагдсан байна.	УТ
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 2 БАТЛАН ХАМГААЛАХ ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭН, БАТЛАН ХАМГААЛАХЫН СӨРӨН ТЭСВӨРЛӨХ ЧАДАВХЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ					
Зорилт 1. Батлан хамгаалах боловсролын тогтолцоог хөгжүүлэх	1."Бүх нийтийн батлан хамгаалах боловсролын үндсэн чиглэл"-ийг боловсруулж, хэрэгжилтийг хангах	Хэрэгжилтийн хувь	-	Хэрэгжилт 100 хувь хангагдсан байна.	-
	2.Төрийн болон төрийн бус байгууллагуудтай батлан хамгаалах боловсролын чиглэлээр сургалт зохион байгуулах	Зохион байгуулсан сургалтын тоо	-	2 жилд 1 сургалт зохион байгуулсан байна.	260.00 УТ
	3.Иргэнд батлан хамгаалах боловсрол олгох чиглэлээр төрийн байгууллагатай хамтран ажиллах	Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо	-	Жилд 1-ээс доошгүй арга хэмжээг зохион байгуулсан байна.	260.00

	4.Боловсролын сургалтын байгууллагын хөтөлбөрт эх оронч үзэл, хүмүүжил олгох агуулгыг тусгах	Батлагдсан хичээлийн хөтөлбөрийн тоо	-	Сургалтын хөтөлбөрт эх оронч үзэл, хүмүүжил олгох агуулгыг тусгаж, хэрэгжүүлсэн байна.	-
Зорилт 2. Орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлэх	1.Орон нутгийн хамгаалалтын сургалт, дадлагыг зохион байгуулах	Сургалт, дадлагын тоо	16 удаагийн сургалт, дадлагыг явуулсан.	35 сургалт, дадлагыг явуулсан байна.	5,700.00 УТ, ОНТ
	2.Орон нутгийн хамгаалалтын удирдах бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулах	Сургалтын тоо	5 удаагийн сургалт явуулсан.	20 сургалт явуулсан байна.	ОНТ
	3.Орон нутгийн цэргийг зэвсэг, галт хэрэглэлээр хангах	Хангалтын хувь	10 хувь	50 хувьд хүргэсэн байна.	ЗХ-ний урсгал хангалт
Зорилт 3. Нэгдсэн удирдлага, төлөвлөлт бүхий дайчилгааны тогтолцоог бэхжүүлэх	1.Дайчилгаатай сургуулийг зохион байгуулж явуулах	Сургуулийн тоо	Зэвсэгт хүчний 2 ангитай зохион байгуулсан.	Зэвсэгт хүчний 4 ангитай зохион байгуулж, явуулсан байна.	3,821.90 УТ
	2.Удирдах албан тушаалтны цэргийн бэлтгэл сургалтыг зохион байгуулах	Сургалтын тоо	10 сургалт явуулсан.	8-16 сургалтыг явуулсан байна.	221.50 УТ, ОНТ
	3.Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулах	Сургалтын тоо	Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудад 40 удаагийн сургалт явуулсан.	Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудад 40 удаагийн сургалт явуулсан байна.	2,041.00 УТ
Зорилт 4. Батлан хамгаалахын аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх	1.Зэвсэг, галт хэрэглэлийн үйлдвэрийн чадавхыг нэмэгдүүлэх	Үйлдвэрлэлийн чадавхыг нэмэгдүүлсэн хувь	10 хувь	100 хувь	81,840.80 УТ
